



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ



Улаанбаатар хот

2019 он

Хянасан:

А.Ариунзаяа

Үндэсний статистикийн хорооны дарга

Ч.Баянчимэг

Үндэсний статистикийн хорооны дэд дарга

А.Дэмбэрэл

Үндэсний статистикийн хорооны ҮТШСГ-ын дарга

Б.Анхзаяа

Үндэсний статистикийн хорооны ҮТШСГ-ын ШСТА-ны ахлах статистикч

Гүйцэтгэсэн:

Ч.Цогзолмаа

Үндэсний статистикийн хорооны ҮТШСГ-ын статистикч

Хамтран ажилласан:

Н.Амарбаясгалан

Үндэсний статистикийн хорооны ХАНСГ-ын статистикч

АГУУЛГА

1. УДИРТГАЛ.....	3
2. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	4
2.1. Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо болон суралцагчид .4	
2.2. Их, дээд сургууль, коллежийн үндсэн багш	11
2.3. Их, дээд сургууль, коллежийг төгсөгчид	14
2.4. Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийг олон улстай харьцуулсан байдал.....	16
2.5. Боловсролын салбарын төсөв, санхүүжилт.....	20
3. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ	21
3.1. Суралцагчдын тооны өөрчлөлтөд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, түүний нөлөө.....	21
3.1.1. Загварчлал.....	22
3.1.2. Үр дүн, тайлбар.....	23
3.2. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын дээд боловсролын суралцагчдын тооны өөрчлөлтөд үзүүлж буй нөлөөлөл	24
3.2.1. Загварчлал.....	24
3.2.2. Үр дүн, тайлбар.....	24
ДҮГНЭЛТ.....	25
ХАВСРАЛТ	27
НОМ ЗҮЙ.....	30

1. УДИРТГАЛ

Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино” гэж заасан байдаг. Мөн дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ¹.

Нийгэм, эдийн засаг хурдацтай хөгжихийн хэрээр дээд боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгддэг. Улс орны эдийн засгийн урт хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дээд боловсролд хөрөнгө оруулалт хийх нь нэн чухал болохыг Монгол Улсын Засгийн газраас онцолсон байдаг. Тэгвэл үүнтэй холбоотойгоор Засгийн газар дээд боловсролын чанарыг нэмэгдүүлж хөгжүүлэхээр дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийг эрчимтэй хэрэгжүүлж байна. Тодруулбал, БСШУСЯ-ны дээд боловсролын газрын дарга Т.Амаржаргалан /доктор, профессор/-гийн “Дээд боловсролын хөгжлийн хандлага, бодлого, чиглэл” судалгааны ажилд дээд боловсролын сургалтын байгууллага ба суралцагчдаас гадна дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд хэрэгжиж буй хүний нөөцийн бүтэц, санхүүжилт болон чанарын баталгаажуулалтын талаар дурдсан байдаг. Мөн Монгол Улсын 15 их, дээд сургуулийн 19 сургалтын хөтөлбөр олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар (APACC, ACBSP, AWEWPR, ASIIN) магадлан итгэмжлэгдсэн, боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх, олон улсад болон дотоодод хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч нарыг бэлтгэх, дээд боловсролын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх ажлууд үе шаттайгаар хийгдэж байгаа талаар тус ажилд дурдсан байдаг.

Энэхүү судалгаагаар дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн чиг хандлага, олон улстай харьцуулсан байдал, нийт суралцагчдын тооны өөрчлөлтөд нөлөөлж буй нийгэм, эдийн засаг ба өрхийн үндсэн хүчин зүйлийн нөлөөллийг судалж, хамаарлыг харуулахыг зорилоо. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсэд Дотоодын нийт бүтээгдэхүүн /2010 оны зэрэгцүүлэх үнээр/, их, дээд сургууль болон коллежийн тоо, сургалтын дундаж төлбөр зэрэг үзүүлэлтүүдийг хамруулсан бол өрхийн үндсэн үзүүлэлтэд нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээг хамруулав. Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн чиг хандлагыг динамик эгнээгээр, харин хүчин зүйлийн нөлөөллийн шинжилгээг нэг болон олон хүчин зүйлийн регрессийн үнэлгээний аргыг ашиглан 2001-2018 оны тоон мэдээлэлд үндэслэн тооцов.

¹ Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 3.1 дүгээр зүйл: Дээд боловсролын агуулга


2. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо болон суралцагчид

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2001/2002 оны хичээлийн жилд 178 байсан бол 2005/2006 оны хичээлийн жилээс тогтмол буурсаар 2018/2019 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн тоо 94 болж, 2001-2002 оны хичээлийн жилтэй харьцуулахад 84 (47.2%)-өөр буурсан байна.


Их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 2001/2002 оны хичээлийн жилд 90.6 мянга байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 157.6 мянга болж, 2001/2002 оны хичээлийн жилтэй харьцуулахад 1.7 дахин өссөн байна.

Зураг 1. Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо болон суралцагчид, мянган хүн, 2001-2018 он



Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоог өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2001/2002 оны хичээлийн жилд нийт их, дээд сургууль, коллежийн 73.0 хувийг төрийн бус өмчийн, 23.0 хувийг төрийн өмчийн, 4.0 хувийг гадаадын их сургуулийн салбар сургууль эзэлж байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд энэ тоо харгалзан 77.7%, 19.1%, 3.2% болсон байна.


Зураг 2. Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллеж, дүнд эзлэх хувиар, өмчийн хэлбэрээр, 2001-2018 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn, БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоог аймгаар авч үзвэл, 2018-2019 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 146.0 мянга (92.6 %) нь Улаанбаатар хотод, 3.6 мянга (2.3 %) нь Дархан-Уул аймагт, 8.0 мянга (5.1 %) нь бусад аймагт суралцаж байна.

Зураг 3. Их, дээд сургууль, коллежид суралцагчид, аймгаар, 2018-2019 оны хичээлийн жилд



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn

Их, дээд сургууль, коллежид 2001 оноос хойш жилд дунджаар 41.2 мянган суралцагч шинээр элссэн бөгөөд тэдгээрийн 70.3 орчим хувь нь тухайн жилдээ ерөнхий боловсролын 12 дугаар анги төгссөн суралцагчид байна.

Зураг 4. Шинээр элсэгчид, тухайн жилд 12 дугаар анги төгсөгчид, мянган хүн, 2001-2018 он




Эх үүсвэр: БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.

Суралцагчдын тоог их, дээд сургууль, коллежийн өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2001/2002 оны хичээлийн жилд төрийн өмчийн сургуульд 60.4 мянга, төрийн бус өмчийн сургуульд 29.9 мянган суралцагч суралцаж байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд төрийн өмчийн сургуульд 88.0 мянга, төрийн бус өмчийн сургуульд 69.4 мянган суралцагчид тус тус суралцаж байна.

Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2001/2002 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 57.3 мянга (63.2 %) нь эмэгтэй суралцагчид байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд энэ үзүүлэлт 93.6 мянга болж, 36.3 мянга (63.2%)-аар өссөн байна.

Зураг 5. Нийт суралцагчид, мянган хүн, хүйсээр, 2001-2018 он




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn,

БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.

Өнгөрсөн жилүүдийн тоон мэдээллээс харахад, дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдал (ЖТБ²)-ын индекс буюу дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 2014/2015 оны хичээлийн жил хүртэл буурч байсан бол 2015/2016 оны хичээлийн жилээс хойш өсөх хандлага ажиглагдаж байна.


Зураг 6. Жендэрийн тэнцвэрт байдлын индекс, 2001-2018 он



Эх үүсвэр: БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.

Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 130.9 мянга (83.0 %) нь бакалавр³, 22.5 мянга (14.3 %) нь магистр, 4.2 мянга (2.7 %) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна. Нийт суралцагчдын тоог 2014/2015 оны хичээлийн жилтэй харьцуулахад бакалаврынх 24.9 мянга (16.0 %)-аар буурсан бол магистрынх 3.4 мянга (18.0 %), докторынх 828 (24.4 %)-аар тус тус өссөн байна.

Зураг 7. Нийт суралцагчид, мянган хүн, боловсролын зэргээр, сүүлийн 5 жилээр




² Жендэрийн тэнцвэрт байдлын индекс нь тухайн шатны боловсролыг эзэмшиж буй 100 эрэгтэй тутамд ногдох эмэгтэйн тоог харуулна.

³ Бакалаврын зэргийн суралцагчдад дипломын дээд болон бакалаврын зэргийн суралцагчдыг оруулсан.

Эх үүсвэр: БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан

Монгол Улсын 18-24 насны хүн амд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцаж буй тухайн насны суралцагчдын дүнд эзлэх хувь⁴ 2018-2019 оны хичээлийн жилд 30.5 % байгаа нь 10 жилийн өмнөх үетэй харьцуулахад 1.0 пунктээр буурсан байна.


Зураг 8. 18-24 насны хүн ам ба бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцаж буй тухайн насны суралцагчдын эзлэх хувь, сүүлийн 10 жилээр



Монгол Улсын хүн амын хэтийн шинэчилсэн тооцоог ашиглаж 18-24 насны хүн амд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцаж буй тухайн насны суралцагчдын өсөлтийг түүхэн дундаж утгад үндэслэн тогтмол гэж таамаглавал 2020 онд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид 100.1 мянга, 2045 онд 171.0 мянган суралцагч суралцахаар байна.


⁴ Бакалаврын зэргийн боловсрол олгох ангид 18-24 насны хүн ам суралцдаг гэж олон улсад үздэг. /OECD/

Зураг 9. Бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцах 18-24 насны суралцагчид, 5 жил тутмын хэтийн төлвөөр



Нийт суралцагчдыг мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд 31.0 мянга (19.7 %) нь худалдаа, бизнесийн удирдлагын чиглэлд, 23.3 мянга (14.8 %) нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлд, 22.4 мянга (14.2 %) нь анагаах ухааны чиглэлд, 16.8 мянга (10.6 %) нь инженерийн чиглэлд, 12.3 мянга (7.8 %) нь хууль, эрх зүйн чиглэлд, 51.9 мянга (32.9 %) нь бусад чиглэлд тус тус суралцаж байна.


Зураг 10. Нийт суралцагчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр, 2001-2018 он



Эх үүсвэр: БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.


Суралцагчдын тоог салбараар авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 50.4 мянга (32.0%) нь, 2008/2009 оны хичээлийн жилд 59.6 мянга (37.0%) нь нийгмийн ухааны салбарын мэргэжлийг сонгон суралцсан байна.

Зураг 11. Нийт суралцагчид, мянган хүн, салбараар



Байгалийн ухаан, техник, технологи, үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбаруудыг эрэгтэй оюутан илүүтэй сонгон суралцаж байна. Тухайлбал, одооноос 10 жилийн өмнө буюу 2008/2009 оны хичээлийн жилд техник, технологийн салбарт нийт 27.3 мянган оюутан суралцаж байсны 66.0% нь, 2018/2019 оны хичээлийн жилд 28.0 мянган оюутан суралцаж байгаагийн 72.3% нь эрэгтэй оюутан байна. Харин анагаах ухааны салбарыг эмэгтэйчүүд илүүтэй сонгон суралцаж байна.

Зураг 12. Нийт суралцагчид, хүйсээр, салбараар




Эх үүсвэр: БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.

Их, дээд сургууль, коллежийн дотуур байранд суухаар 2018/2019 оны хичээлийн жилд хүсэлт ирүүлсэн нийт 12.5 мянган оюутан байгаагийн 11.4 мянга (91.6%) нь өөрийн суралцаж буй сургуулийн дотуур байранд амьдарч байгаа бол 667 (0.5%) нь өөр сургуулийн дотуур байранд амьдарч байна.

2.2. Их, дээд сургууль, коллежийн үндсэн багш

Их, дээд сургууль, коллежийн үндсэн багшийн тоо 2001/2002 оны хичээлийн жилд 5.3 мянга байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 6.7 мянга болж, 1.3 мянга (24.7 %) -аар өссөн байна. Үндсэн багшийн тоог хүйсээр авч үзвэл, 2001/2002 оны хичээлийн жилд нийт багшийн 3.0 мянга (52.3 %) нь, 2018/2019 оны хичээлийн жилд 4.0 мянга (60.4 %) нь эмэгтэй багш байна.

Зураг 13. Их, дээд сургууль, коллежийн үндсэн багш, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2001-2018 он




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn


Их, дээд сургууль, коллежийн үндсэн багшийг насны бүлгээр авч үзвэл, 3.8 мянга (57.5 %) нь 30-50 насных, 1.2 мянга (18.0 %) нь 30 хүртэлх насных, харин 437 (6.6 %) нь 60, түүнээс дээш насны багш байна.

Мөн үндсэн багшийг албан тушаалаар авч үзвэл, 2.8 мянга (41.9 %) нь багш, 1.9 мянга (29.0 %) нь ахлах багш байгаа бол 640 (9.6 %) нь профессор цолтой багш байна.

Зураг 14. Үндсэн багш, насны бүлгээр, 2018 он




Зураг 15. Үндсэн багш, албан тушаалаар, 2018 он



Эх үүсвэр: БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.

Үндсэн багшийг ажилласан жилээр авч үзвэл, 1.5 мянга (22.4 %) нь 6-10 жил ажилласан бол 731 (11.0 %) нь 21-25 жил ажилласан байна.


Зураг 16. Үндсэн багш, ажилласан жилээр, 2018 он



Эх үүсвэр: БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.

2001/2002 оны хичээлийн жилд нэг багшид 17.1 оюутан ногдож байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 39.4 хувиар нэмэгдэж нэг багшид 23.6 оюутан ногдож байна.


Зураг 17. Нэг багшид ногдох суралцагчид, 2001-2018 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn

Нэг багшид ногдох оюутны тоог аймгаар авч үзвэл, Улаанбаатар болон Баянхонгор, Архангай аймгуудад 2018-2019 оны хичээлийн жилд нэг багшид 24.8-26.0 оюутан ногдож байгаа бол Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, Завхан, Дорноговь, Хөвсгөл аймгуудад нэг багшид 10 хүрэхгүй оюутан ногдож байна.

Зураг 18. Нэг багшид ногдох суралцагчид, аймгаар, 2018-2019 оны хичээлийн жилд




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn

2.3. Их, дээд сургууль, коллежийг төгсөгчид


Их, дээд сургууль, коллежийг 2001/2002 оны хичээлийн жилд нийт 17.7 мянган оюутан төгсөж байсан бол 2017/2018 оны хичээлийн жилд 29.2 мянга болж, 11.5 мянга (65.0 %) -аар өссөн байна. 2017/2018 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 17.5 мянга (59.9 %) нь эмэгтэй төгсөгчид байна.

Зураг 19. Нийт төгсөгчид, мянган хүн, хүйсээр, 2001-2018 он



Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2017/2018 оны хичээлийн жилд 25.2 мянга (86.3 %) нь бакалавр, 3.9 мянга (13.3 %) нь магистр, 131 (0.4 %) нь докторын зэрэг эзэмшсэн байна. Нийт төгсөгчдийн тоог 2013/2014 оны хичээлийн жилтэй харьцуулахад бакалаврынх 4.5 мянга (15.4 %), магистрынх 128 (3.3 %) -аар тус тус буурсан бол докторынх 13 (11.0 %) -аар өссөн байна.

Зураг 20. Нийт төгсөгчид, мянган хүн, боловсролын зэргээр, сүүлийн 5 жилээр




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn, БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан.

Нийт төгсөгчдийг мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр авч үзвэл, 2017/2018 оны хичээлийн жилд 6.4 мянга (22.0 %) нь худалдаа, бизнесийн удирдлагын чиглэлээр, 4.7

мянга (16.2 %) нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлээр, 3.9 мянга (13.5 %) нь инженерийн чиглэлээр, 3.3 мянга (11.2 %) нь анагаах ухааны чиглэлээр, 2.2 мянга (7.6 %) нь хууль, эрх зүйн чиглэлээр, 8.6 мянга (29.5 %) нь бусад чиглэлээр тус тус төгссөн байна.


Зураг 30. Нийт төгсөгчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр, 2001-2018 он



Эх үүсвэр: БСШУСЯ-ны дээд боловсролын жилийн статистикийн тайлан


Төгсөгчдийн тоог салбараар авч үзвэл, 2017/2018 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 9.8 мянга (33.6%) нь, 2008/2009 оны хичээлийн жилд 14.7 мянга (44.4%) нь нийгмийн ухааны салбарын мэргэжлээр төгссөн байна.

Зураг 31. Нийт төгсөгчид, мянган хүн, салбараар



2008/2009 оны хичээлийн жилд техник, технологийн салбарт 3.9 мянган оюутан төгссөний 57.4 хувь нь, 2017/2018 оны хичээлийн жилд 6.5 мянган оюутан төгссөний 68.2 хувь нь эрэгтэй төгсөгчид байна. Харин анагаах ухааны салбарт 2008/2009 оны хичээлийн жилд 2.4 мянган оюутан төгссөний 83.7 хувь нь, 2017/2018 оны хичээлийн жилд 3.3 мянган оюутан төгссөний 82.5 хувь нь эмэгтэй төгсөгчид байна.

Зураг 32. Нийт төгсөгчид, хүйсээр, салбараар




2.4. Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийг олон улстай харьцуулсан байдал⁵

Дэлхийн эдийн засгийн форум (The World Economic Forum) “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-д боловсролын чанараар тэргүүлэх улс орнуудыг жагсаасан байдаг. Тус жагсаалтад багтсан зарим улс орнуудын нэг багшид ногдох суралцагчдын тоог харьцуулан дараах зурагт харуулав. Нэг багшид ногдох суралцагчдын тоогоор хамгийн бага нь Норвеги улс (9.6), хамгийн их нь Колумби улс (30.7) байна. Харин Монгол Улсад нэг багшид 22.7 оюутан ногдож байна.


⁵Мэдээллийг эх үүсвэр: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Боловсролын үзүүлэлт, 2016

Зураг 33. Нэг багшид ногдох суралцагчид, улсаар



25-64 насны хүн амд⁶ дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй тухайн насны суралцагчдын эзлэх хувийг 2017 оны байдлаар авч үзвэл, АНУ 46.4 хувь, Их Британи болон Ирланд 45.7 хувь, Финланд 44.3 хувь байгаа нь хамгийн өндөр байна. Харин Монгол Улсад дээрх улсуудтай харьцуулахад бага буюу 25-64 насны нийт хүн амын 9.7 хувь нь дээд боловсрол эзэмшихээр суралцаж байна.


Зураг 34. 25-64 насны хүн амд дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй тухайн насны суралцагчдын эзлэх хувь, улсаар



⁶ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага нь 25-64 насны хүн амыг насанд хүрэгчид гэж авч үздэг. Тооцоолол: 25-64 насны хүн амд дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй тухайн насны суралцагчдын эзлэх хувь.


Монгол Улсад нийт багш нарын талаас илүү хувь нь эмэгтэй багш байсан бол олон улсад энэ нь эсрэгээрээ байна. Тухайлбал, Итали болон Колумби улсад тус бүр нийт багшийн 63.0 хувь нь, ХБНГУ-д 60.9 хувь нь эрэгтэй багш байна.

Зураг 35. Эмэгтэй багш, дүнд эзлэх хувиар, улсаар




Олон улсын түвшинд авч үзвэл, нийт төгсөгчдийн дийлэнх хувь нь санхүү, бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн байна. Тухайлбал, Бразил улсад 35.6% нь, Турк улсад 34.6% нь, ОХУ-д 33.1% нь, Монгол улсад 24.9% нь, ХБНГУ-д 23.4% нь, Их Британи-д 22.0% нь энэ чиглэлээр төгссөн байна.

Зураг 36. Нийт төгсөгчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн чиглэлээр, улсаар




Их Британи улсын нийт суралцагчдын 18.1% нь, Австри улсын 16.3% нь, Бельги улсын 12.0% нь, Нидерланд улсын 10.7% нь гадаад оюутан байгаа бол Монгол Улсын нийт суралцагчдын 1.0% нь, Мексик, Бразил, Колумби, Индонез улсуудад 1 хүрэхгүй хувийг гадаад оюутнууд эзэлж байна.

Зураг 37. Гадаад оюутан, дүнд эзлэх хувиар, улсаар



Монгол Улсад 2018/2019 оны хичээлийн жилд нийт 2275 гадаад оюутан суралцаж байгаагийн 82.5 хувийг хөрш зэргэлдээ 2 улсын оюутнууд эзэлж байна. Тодруулбал, 1.6 мянга (72.1 %) нь БНХАУ-ын, 236 (10.4 %) нь ОХУ-ын оюутнууд байна.

Зураг 38. Монгол Улсад суралцаж буй гадаад оюутан, нийт дүнд эзлэх хувиар, улсаар



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, боловсролын салбарын захиргааны мэдээ

2.5. Боловсролын салбарын төсөв, санхүүжилт

Монгол Улс 2000 онд боловсролын салбарын нийт зардалд 91.5 тэрбум төгрөг, 2010 онд 522.0 тэрбум төгрөг зарцуулж байсан буюу дараагийн 10 жилд санхүүжилт даруй 5.7 дахин өсөв. 2014 оноос хойш боловсролын салбарт зарцуулж буй зардлын хэмжээ 1.0 их наяд төгрөгөөс давсаар 2018/2019 оны хичээлийн жилд 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна.

Төсвийн зарлагын дүнд боловсролын салбарын зардлын эзлэх хувийг авч үзвэл, 2001/2002 оны хичээлийн жилд 20.2% байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 15.0% болж, 5.2 пунктээр буурсан байна. Мөн МУ-ын Дотоодын нийт бүтээгдэхүүн (2010 оны зэрэгцүүлэх үнээр)-нд эзлэх боловсролын салбарын зардлын хэмжээ 2001/2002 оны хичээлийн жилд 2.0% байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 7.7% болж, 5.7 пунктээр өссөн байна.

Зураг 39. Улсын нэгдсэн төсвийн зарлага болон ДНБ-нд боловсролын салбарын зардлын эзлэх хувь, 2001-2018 он




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn

Төсвөөс олгосон санхүүжилтийг нарийвчлан авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй дотоодын оюутнуудад 99.9 тэрбум төгрөгийг, Монголд суралцаж буй гадаад оюутнуудад 0.9 тэрбум төгрөгийг, харин гадаадад суралцаж буй Монгол оюутнуудад зориулан 25.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

3. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Дээд боловсролын эрэлтийн үзүүлэлтийг тухайн шатны боловсролын байгууллагад тайлант оны нийт суралцагчдын тоогоор, харин нийлүүлэлтийг тайлант онд тухайн шатны боловсролыг бүрэн эзэмшсэн төгсөгчдийн тоогоор илэрхийлэх нь зүйтэй гэж судлаачид үздэг. Дээд боловсролын эрэлтийн хүчин зүйл болох суралцагчдын тоо нь бүрэн дунд боловсролыг бүрэн эзэмшсэн төгсөгчдөөс шууд хамаарна. Тэгвэл энэхүү хамаарлыг өөр нэг сонирхолтой талаас нь дараах байдлаар таамаглавал:

- Дээд боловсролын эрэлт нь өмнөх оны нийлүүлэлттэй эерэг хамааралтай буюу тайлант оны суралцагчдын тоо болон өмнөх оны төгсөгчдийн тоо хооронд эерэг шугаман хамааралтай. /Зураг А/
- Тайлант оны төгсөгчдийн тоо болон тухайн жилийн үндсэн багш нарын тоо хооронд эерэг шугаман хамааралтай. /Зураг Б/



Дээд боловсролын үндсэн үзүүлэлт болох суралцагчдын тооны өөрчлөлтөд нийгэм, эдийн засгийн болон өрхийн үзүүлэлтүүдийн өөрчлөлт хэр зэрэг нөлөөлөхийг дараагийн хэсэгт харуулав.

3.1. Суралцагчдын тооны өөрчлөлтөд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, түүний нөлөө

Их, дээд сургуулийн суралцагчдын тооны өөрчлөлтийг олон талаас тайлбарлаж болно. Улс орны эдийн засгийн өсөлт, бууралтаас шалтгаалсан объектив болон субъектив хүчин зүйлийн нөлөөгөөр аливаа үзэгдлийн өөрчлөлт тодорхой түвшинд хэлбэлзэлд ордог. Жишээлбэл, Засгийн газрын өр нэмэгдсэнээр өрийн төлбөрийн дарамт нэмэгдэж улмаар Төв банк бэлэн мөнгө хэвлэн эргэлтэд оруулах нөхцөл үүсдэг. Ингэснээр зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, улмаар инфляц өсөх шалтгаан болдог байна. Инфляц өсөхөд мөнгө үнэгүйдэж бараа таваарын гүйлгээ болон төлбөр хийх үүргээ алддаг. Энэ нь өрх, хүн ам төдийгүй эдийн засагт дарамт учруулна.

Энэ хэсэгт их, дээд сургуулийн суралцагчдын тооны өөрчлөлтөд үзүүлэх нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөг онцгойлон авч үзье.

3.1.1. Загварчлал

Нийгэм, эдийн засгийн судалгаанд нэг хүчин зүйлийн өөрчлөлт нь нөгөө хүчин зүйлийн өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж байгаа талаар судлах олон арга байдгийн нэг нь регрессийн арга юм. Регрессийн олон төрлийн арга, үнэлгээний хэлбэр байх бөгөөд судалгаанд ашиглах тоон мэдээллийн шинж чанараас хамааран хамгийн тохиромжит үнэлгээний аргыг сонгох нь нарийвчлал өндөртэй, алдаа багатай үр дүн гаргахад өндөр ач холбогдолтой. Энэхүү судалгаанд “Энгийн шугаман регресс”-ийн загварын өргөтгөсөн хэлбэр болох олон хүчин зүйлийн регрессийн загварыг ашиглав.

Загвар	Олон хувьсагч бүхий шугаман регрессийн загвар
Хувьсагчид	Хамаарах хувьсагч: Суралцагчдын тоо
	Тайлбарлах хувьсагч: 1. /PAYMENT/ - Сургалтын дундаж төлбөр 2. /GDP/ - Дотоодын нийт бүтээгдэхүүн /2010 оны зэрэгцүүлэх үнээр/ 3. /MSVT(-1)/ - Хугацааны нэг хоцрогдол бүхий МСҮТ-ийн суралцагчид 4. /SCHOOL/ - Их, дээд сургууль, коллежийн тоо
Таамаглал	$H_0 : \beta_1 = \beta_2 = \beta_3 = \beta_4 = 0$ $H_1 : \beta_1 \neq 0, \beta_2 \neq 0, \beta_3 \neq 0, \beta_4 \neq 0$
Тэгшитгэл	$Y_t = \beta_0 + \beta_1 * X_{1,t} + \beta_2 * X_{2,t} + \beta_3 * X_{3,t} + \beta_4 * X_{4,t} + \varepsilon_t$
Мэдээллийн эх үүсвэр	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn БСШУСЯ-ны статистик мэдээ Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
Хугацааны цуваа	2001-2018 он

Тэгшитгэлийг дараах үндсэн алхмаар үнэлэв. Үүнд:

Алхам 1: Хугацааны цувааны өгөгдөл дэх Хамгийн бага квадратын аргаар (ХБКА-Least Squares Method) шугаман регрессийг загварчлах.

Загварын шугаман болон шугаман бус байдлыг харгалзан олон хүчин зүйлийн “log~log” загварыг үнлэв.

$$\ln(y) = \beta_0 + \beta_1 * \ln(X_{1,t}) + \beta_2 * \ln(X_{2,t}) + \beta_3 * \ln(X_{3,t}) + \beta_4 * \ln(X_{4,t}) + \varepsilon_t$$

$$\ln(\widehat{\text{Суралцагчид}}_t)$$

$$= \beta_0 + \beta_1 * \ln(\widehat{\text{PAYMENT}}_t) + \beta_2 * \ln(\widehat{\text{GDP}}_t) + \beta_3 * \ln(\widehat{\text{MSVT}(-1)}_t) + \beta_4 * \ln(\widehat{\text{SCHOOL}}_t) + \varepsilon_t$$

Алхам 2 ба 3: Шугаман регрессийн сонгодог загварт алдааны илэрхийлэл нь автокорреляцигүй байна гэсэн нөхцөл тавьдаг. Энэхүү нөхцөл хангагдаж байгаа эсэхийг шалгах, илрүүлэх, засварлах

Шигтгээ: Цаг хугацааны тоо мэдээг авч үзэх тохиолдолд тоо мэдээ нь цаг хугацааны дарааллаар эрэмбэлэгдэх бөгөөд t хугацааны үзүүлэлт нь (t-1) хугацааны үзүүлэлттэй холбоотой байх үе байдаг. Энэ үед автокорреляци үүсдэг. Ихэвчлэн

санхүүгийн чиглэлийн хугацааны цувааны үзүүлэлтүүдээр үнэлгээ хийхэд автокорреляцитай эсэхийг зайлшгүй шалгах шаардлагатай байдаг. Хэрэв автокорреляцитай бол түүнийг засварлан үнэлснээр тухайн үнэлгээний үр дүн болон тэгшитгэл нь сайн, алдаа багатай чанараа хадгална.

Автокорреляцийг Durbin-Watson-ний “d” статистикийг ашиглан $d \approx 2(1 - \hat{\rho})$ нэгдүгээр эрэмбийн автокорреляцийн коэффициентээр тодорхойлно. Хэрэв ρ нь эерэг автокорреляцитай бол $0 \leq d \leq 2$, сөрөг автокорреляцитай бол $2 \leq d \leq 4$ утгатай байна. Манай тохиолдолд эерэг автокорреляцитай буюу $d = 1.734704$ байна. Тиймээс энэ тохиолдолд Newey-West-ийн томъёолсон үнэлгээ болох HAC (Heteroskedasticity and Autocorrelation Consistent)-ийг ашиглан автокорреляцийг засварлав. Засварлах үнэлгээ нь тайлбарлагч хувьсагчийн коэффициентод ямар нэг өөрчлөлт оруулахгүйгээр стандарт алдаа болон t-статистик утгуудад өөрчлөлт оруулж үнэлгээг сайжруулдаг.

3.1.2. Үр дүн, тайлбар

Сургалтын дундаж төлбөр, Дотоодын нийт бүтээгдэхүүн /2010 оны зэрэгцүүлэх үнээр/, Хугацааны нэг хоцрогдол бүхий МСҮТ-ийн суралцагчид болон Их, дээд сургууль, коллежийн тооны өөрчлөлт нь тайлант оны их, дээд сургуульд суралцагчдын тооны өөрчлөлтөд нөлөөлөхгүй гэсэн тэг таамаглал, харин өрсөлдөгч таамаглалаар дээрх 4 хүчин зүйлийн ядаж нэг нь нөлөөтэй гэж дэвшүүлсэн болно. Засварлагдсан үнэлгээний үр дүнгээр тэгшитгэл дараах хэлбэртэй байна.

$$H_0 : \beta_1 = \beta_2 = \beta_3 = \beta_4 = 0$$

$$H_1 : \beta_1 \neq 0, \beta_2 \neq 0, \beta_3 \neq 0, \beta_4 \neq 0$$

$$\widehat{student}_t = -9.179945 - 0.352155 * \widehat{PAYMENT}_t + 0.898639 * \widehat{GDP}_t + 0.606338 * \widehat{MSVT}_t + 0.537315 * \widehat{SCHOOL}_t$$

- Цаг хугацааны өгөгдөлд үндэслэн тооцсон үнэлгээний үр дүнгээр:
 - Бусад хүчин зүйлийг тогтмол буюу өөрчлөлтгүй гэж үзэх тохиолдолд их, дээд сургуулийн дундаж төлбөрийн хэмжээ 1%-иар нэмэгдэхэд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.35%-иар буурах хандлагатай буюу дээрх 2 хүчин зүйл хоорондоо сөрөг хамааралтай байна.
 - ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.89%-иар өсөх хандлагатай буюу дээрх 2 хүчин зүйл хоорондоо эерэг хамааралтай байна.
 - Хугацааны нэг хоцрогдол бүхий МСҮТ-д суралцагчдын тоо 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.60%-иар, их, дээд сургууль болон коллежийн тоо 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.54%-иар тус тус өсөх хандлагатай буюу дээрх хүчин зүйлс хоорондоо эерэг хамааралтай байна.
- Тайлбарлагч хувьсагчид маань хамаарах хувьсагч болох дээд боловсролын суралцагчдын тооны өөрчлөлтийн 94.8%-ийг тайлбарлаж, харин бусад хүчин зүйлийн нөлөө үлдсэн 5.2%-ийг тайлбарлаж байна.

3.2. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын дээд боловсролын суралцагчдын тооны өөрчлөлтөд үзүүлж буй нөлөөлөл

Их, дээд сургуулийн төлбөрийн хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа нь дээд боловсрол эзэмшиж буй суралцагчид, шинээр элсэгчид, тэдгээрийн гэр бүл дэх төлбөрийн дарамтыг улам ихээр нэмэгдүүлж байна. Тэгвэл төлбөрийн дарамтыг эсэргүүцэх хүчин зүйл болох өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээг дээд боловсролын салбарын суралцагчдын тооны өөрчлөлтөд эерэгээр нөлөөлнө гэж таамаглая.

3.2.1. Загварчлал

Нэг хүчин зүйлийн “Шугаман регресс”-ийн загварыг “Хамгийн бага квадратын арга”-аар 3.1 дүгээр бүлэгт дурдсанчлан хувьсагчдыг логарифм хэлбэрт шилжүүлэх замаар шугаман загварыг үнэлэв.

Model	Энгийн шугаман регрессийн загвар
Хувьсагчид	Хамаарах хувьсагч: Суралцагчдын тоо
	Тайлбарлах хувьсагч: Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, төгрөг
Таамаглал	$H_0 : \beta_1 = 0$ $H_1 : \beta_1 \neq 0$
Загварчлал	$\ln(Y_t) = \beta_0 + \beta_1 * \ln(X_t) + \varepsilon_t$
Мэдээллийн эх үүсвэр	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn БСШУСЯ-ны статистикийн мэдээлэл Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
Хугацааны цуваа	1995-2017 он

Засварлагдсан үнэлгээний үр дүн:

$$\ln(\widehat{\text{Суралцагчдын тоо}}_t) = \beta_0 + \beta_1 * \ln(\widehat{\text{Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого}}_t) + \varepsilon_t$$

$$\ln(\widehat{\text{student}}_t) = 5.631721 + 0.406026 * \ln(\widehat{\text{HH_income}}_t)$$

3.2.2. Үр дүн, тайлбар

Суралцагчдын тооны өөрчлөлтөд нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ нөлөөлөхгүй гэсэн тэг таамаглал, харин өрсөлдөгч таамаглалаар тэгээс ялгаатай ($\beta_1 \neq 0$) буюу нөлөөтэй гэж дэвшүүлсэн. Засварласан үнэлгээний үр дүнгээр⁷:

- Цаг хугацааны 23 жилийн өгөгдөлд үндэслэн тооцсон үнэлгээний үр дүнгээс харахад нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ 1%-иар нэмэгдэхэд тухайн хичээлийн жилд дээд боловсрол эзэмших суралцагчдын тоо дунджаар 0.4%-аар нэмэгдэхээр байна.

⁷ $H_0 : \beta_1 = 0$ буюу дээд боловсролын салбар дахь суралцагчдын тооны өөрчлөлтөд нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ нөлөөгүй гэсэн тэг таамаглалыг 5%-ийн ач холбогдлын түвшинд няцааж байна. Өөрөөр хэлбэл, нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ нь суралцагчдын тооны өөрчлөлтөд эерэг нөлөөтэй байна.

ДҮГНЭЛТ

- Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2004/2005 оны хичээлийн жилд хамгийн олон буюу 183 байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 94 болж, 2 дахин буурсан байна. Нийт сургалтын байгууллагын дийлэнх хувийг төрийн бус өмчийн сургууль эзэлж байгаа бөгөөд 2001/2002 оны хичээлийн жилтэй харьцуулахад төрийн бус өмчийн сургууль 4.7 пунктээр өссөн бол төрийн өмчийн сургууль 3.9 пунктээр буурсан байна. Их, дээд сургууль, коллежийн 76.6 хувь нь 2018/2019 оны хичээлийн жилд магадлан итгэмжлэгдсэн байна.
- Их, дээд сургууль, коллежид 2001/2002 оны хичээлийн жилд нийт 90.6 мянган суралцагч байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 157.6 мянга болж, 1.7 дахин өссөн хэдий ч 10 жилийн өмнөх үетэй харьцуулахад 2.2 хувиар буурсан байна. Нийт суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 130.9 мянга (83.0 %) нь бакалавр, 22.5 мянга (14.3 %) нь магистр, 4.2 мянга (2.7 %) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна.
- Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 146.0 мянга (92.6 %) нь Улаанбаатар хотод, 11.6 мянга (7.4 %) нь хөдөө, орон нутагт суралцаж байна.
- Монгол Улсын хүн амын хэтийн шинэчилсэн тооцоог ашиглаж 18-24 насны хүн амд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцаж буй тухайн насны суралцагчдын өсөлтийг түүхэн дундаж утгад үндэслэн тогтмол гэж таамаглавал 2020 онд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцах суралцагчдын тоо энэ хичээлийн жилээс 4.0 хувиар буурах бол 2045 онд 64.0 хувиар өсөх магадлалтай байна.
- Сүүлийн 18 жилийн турш худалдаа, бизнесийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын тоо бусад мэргэжлийн чиглэлүүдээс өндөр хэвээр байна. Тодруулбал, нийт суралцагчдын 16.5-24.3 хувь нь энэ чиглэлээр суралцаж байна. Харин нийтийн мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр бусад мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад харьцангуй цөөн оюутан суралцах хандлагатай байна. Өндөр өсөлт, бууралттай чиглэлүүдийг авч үзвэл, сүүлийн 18 жилийн хугацаанд архитектур, хот төлөвлөлтийн чиглэлээр суралцагчдын тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад өндөр өсөлттэй байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 294 оюутан суралцаж байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 6.1 мянга болж, 20.7 дахин нэмэгджээ. Харин нийгмийн шинжлэлийн чиглэлээр суралцагчдын тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад нилээд буурсан байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 7.8 мянган оюутан суралцаж байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 5.5 мянга болж, 30.0 хувиар буурчээ.
- Монгол Улсад суралцаж буй гадаад оюутнуудын тоо сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаагийн зэрэгцээ олон улсад өрсөлдөхүйц боловсон хүчин бэлдэхийн тулд их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийн тодорхой хэсгийг англи хэлээр заах шаардлага бий болж байна.
- Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн тоо 2001/2002 оны хичээлийн жилтэй харьцуулахад 20.0 орчим хувиар өссөн хэдий ч нэг багшид ногдох суралцагчдын тоо буурахгүй өссөөр байгаа нь нийт суралцагчдын тооны өсөлттэй уялдаатай юм.
- Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2017/2018 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 25.2 мянга (86.3%) нь бакалавр, 3.9 мянга (13.3%) нь магистр, 131 (0.4%) нь докторын зэргээр суралцаж төгссөн байна.

- Сүүлийн 18 жилийн турш худалдаа, бизнесийн чиглэлээр суралцаж төгссөн оюутны тоо бусад мэргэжлийн чиглэлүүдээс өндөр хэвээр байна. Тодруулбал, нийт суралцагчдын 21.4-28.7 хувь нь энэ чиглэлээр төгссөн байна. Харин нийтийн мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр бусад мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад харьцангуй цөөн оюутан төгссөн байна. Өндөр өсөлт, бууралттай чиглэлүүдийг авч үзвэл, сүүлийн 18 жилийн хугацаанд архитектур, хот төлөвлөлтийн чиглэлээр төгссөн оюутны тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад өндөр өсөлттэй байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 38 оюутан төгсөж байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 1.7 мянга болж, 43.6 дахин нэмэгджээ. Харин нийгмийн шинжлэлийн чиглэлээр төгссөн оюутны тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад нилээд өндөр дүнгээр буурсан байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 1.7 мянган оюутан төгсөж байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 875 болж, 48.4 хувиар буурчээ.
 - Мэргэжлийн чиглэлүүд дэх суралцагч болон төгсөгчдийн тооны өндөр дүнгээрх өөрчлөлт нь мэргэжлийн чиглэл хооронд шилжин суралцаж буй төлөв байдалтай холбоотой.
 - 2017/2018 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 10.0 мянга (34.4%) нь ажлын байртай болсон нь хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрийг хангах, энэ чиглэлийн төрийн бодлого, хөтөлбөр шаардлагатай байгааг харуулж байна.
- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнгээс харвал, сүүлийн 6 жилийн байдлаар өрхүүд гишүүдийнхээ боловсролд нийт мөнгөн орлогынхоо 2.3-3.8 хувийг зарцуулсан нь тухайн өрхийн хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 3.3-5.0 хувийг тус тус эзэлж байна.
- Боловсролын чанараар тэргүүлэх улс, орнуудтай харьцуулахад Монгол Улсын нэг багшид ногдох суралцагчдын тоо өндөр, харин 25-64 насны хүн амд дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй энэ насны суралцагчдын эзлэх хувь бага байна. Олон улс дахь мэргэжлийн тэргүүлэх чиглэл нь санхүү, бизнесийн удирлага байгаа нь Монгол Улсад мөн адил тэргүүлж байна.
- Нийт суралцагчдын тооны өөрчлөлтөд сургалтын дундаж төлбөр сөрөг харин дотоодын нийт бүтээгдэхүүн, их, дээд сургууль, коллежийн тоо болон нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ эерэг нөлөөтэй байна. Тодруулбал:
 - Их, дээд сургуулийн төлбөрийн дундаж хэмжээ 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.35%-иар буурах хандлагатай буюу дээрх 2 хүчин зүйл хоорондоо сөрөг хамааралтай байна. Харин ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.89%-иар, их, дээд сургууль, коллежийн тоо 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.54%-иар өсөх хандлагатай байна.
 - Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ 1%-иар нэмэгдэхэд тухайн хичээлийн жилд дээд боловсрол эзэмших суралцагчдын тоо дунджаар 0.4%-аар нэмэгдэх хандлагатай байна.

ХАВСРАЛТ

Хүснэгт Х.1. Үндсэн үзүүлэлтүүд

Он	Суралцагчдын тоо	Төгсөгчдийн тоо	МСҮТ-ийн суралцагчид	Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, төг	Сургалтын дундаж төлбөр, мян.төг	Дотоодын нийт бүтээгдэхүүн, мян.төг /2010 оны зэрэгцүүлэх үнээр/	Дээд боловсролын үндсэн багшийн тоо	Их, дээд сургууль, коллежийн тоо
2001	90 644	17 671	15 051	102 133	217.9	5 360 870.5	5 346	178
2002	98 453	18 289	19 493	124 930	251.4	5 614 599.3	5, 642	185
2003	108 738	21 109	21 574	144 354	258.1	6 007 881.5	5 990	183
2004	123 824	22 397	21 712	144 127	297.8	6 646 243.3	6 337	184
2005	138 019	23 628	23 249	150 208	343.5	7 128 339.5	6 517	180
2006	142 411	25 938	24 766	173 477	396.3	7 738 257.0	6 818	170
2007	150 326	29 599	29 906	239 179	457.2	8 531 274.9	6 892	162
2008	161 111	33 007	37 867	325 270	527.5	9 290 589.7	7 020	154
2009	164 773	34 211	44 681	354 967	608.6	9 172 729.4	7 219	146
2010	170 126	35 847	46 071	387 099	723.5	9 756 588.4	7 183	113
2011	172 798	37 749	48 134	503 936	859.3	11 443 578.4	7 295	101
2012	175 591	37 243	45 225	741 917	1007.6	12 853 406.6	7 331	99
2013	174 075	33 850	42 798	862 511	1221.1	14 350 689.2	7 385	100
2014	178 295	35 181	42 797	974 392	1542.1	15 482 273.4	7 528	101
2015	162 626	35 889	42 675	945 118	1765.2	15 850 726.1	7 121	100
2016	157 138	34 681	40 134	863 259	1932.6	16 035 924.9	6 917	95
2017	155 248	29 164	35 831	936 187	2124.7	16 886 096.5	6 724	96
2018	157 625	-	37 039	1 082 372	2 233.3	18 059 484.1	6 668	94

Хүснэгт Х.2. Олон улсын харьцуулсан үзүүлэлт

Улс			Нэг багшид ногдох суралцагчид, 2016 он	25-64 насны хүн амд дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй тухайн насны суралцагчдын эзлэх хувь, 2017 он	Гадаад оюутан, дүнд эзлэх хувиар, 2016 он
AUT	Austria	Австри	14.4	32.39439	16.349
BEL	Belgium	Бельги	21.2	40.257053	12.022
BRA	Brazil	Бразил	25.1	-	0.24
COL	Columbia	Колумби	30.7	22.491623	0.164
FIN	Finland	Финланд	15.3	44.304253	7.806
DEU	Germany	Герман	12.1	28.58337	8.037
IND	Indonesia	Индонез	23.7	11.857569	0.138
IRL	Ireland	Ирланд	20.8	45.65897	8.188
ITA	Italy	Итали	20.2	18.669672	5.102
MEX	Mexico	Мексик	17.5	17.418995	0.298
MGL	Mongolia	Монгол	22.7	9.65	-
NOR	Norway	Норвеги	9.6	43.207031	3.921
RUS	Russia	ОХУ	10.9	-	4.042
ESP	Spain	Испани	12.2	36.351273	2.713
SWE	Sweden	Швед	10.4	41.936691	6.577
TUR	Turkey	Турк	23.1	20.013071	1.314
GBR	United Kingdom	Их Британи	15.8	45.744305	18.096
USA	United States	АНУ	14.2	46.3568	5.036

Хүснэгт Х.2а. Төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр

Улс			Боловсрол	Эрүүл мэнд	Соёл, урлаг	Инженер	Нийгмийн шинжлэх ухаан	Санхүү, Бизнесийн удирдлага	Бусад
AUT	Austria	Австри	12.2	7.4	7.5	20.5	11.3	21.7	19.3
BEL	Belgium	Бельги	8.8	27.3	10.3	11.9	10.6	21.8	9.3
BRA	Brazil	Бразил	19.7	13.9	3.2	11.0	4.5	35.6	12.1
COL	Columbia	Колумби	8.2	6.8	3.9	16.7	6.6	45.9	11.8
FIN	Finland	Финланд	6.4	19.7	12.3	17.7	7.2	18.3	18.4
DEU	Germany	Герман	9.9	7.3	11.7	22.1	7.1	23.4	18.4
IND	Indonesia	Индонез	9.1	3.2	5.6	11.7	31.5	17.8	21.1
IRL	Ireland	Ирланд	5.7	17.1	13.8	10.3	6.3	25.0	21.9
ITA	Italy	Итали	3.6	15.2	17.7	16.4	13.7	21.3	12.0
MEX	Mexico	Мексик	13.8	9.7	3.6	21.3	9.2	35.2	7.2
MGL	Mongolia	Монгол	15.0	12.6	2.0	12.4	5.1	24.9	28.0
NOR	Norway	Норвеги	16.6	20.6	8.3	12.6	11.2	16.1	14.6

RUS	Russia	ОХУ	7.3	6.1	4.4	22.9	10.1	33.1	16.0
ESP	Spain	Испани	16.5	16.0	9.1	14.9	7.1	18.6	17.7
SWE	Sweden	Швед	12.2	22.2	6.0	18.3	13.0	17.1	11.2
TUR	Turkey	Турк	9.6	10.1	11.1	14.2	8.2	34.6	12.2
GBR	United Kingdom	Их Британи	9.3	13.4	15.4	9.1	11.9	22.0	18.9
USA	United States	АНУ	6.8	17.0	19.7	6.9	12.0	19.3	18.3

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

- Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Статистикийн жилийн эмхтгэл (2005-2017).
- Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүн, тайлан (2012-2017).
- Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам. Жилийн тайлан (2000-2017).
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Азийн хөгжлийн банк. “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”.
- Монгол Улсын Засгийн газар. Монголын боловсролын 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө.
- Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг. “Боловсролын салбарын тойм судалгаа” 2013 он.
- Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Монгол Улсын “Боловсролын тухай” хууль, Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хууль.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2015, 2016, 2017, 2018”
- А.Заяадэлгэр. “Боловсролын эдийн засаг”, 2011 он.
- Т.Амаржаргалан. “Дээд боловсролын хөгжлийн хандлага, бодлого, чиглэл”

Англи хэлээр:

- World bank. World development indicators
- OECD. Education indicators
- Nizamettin Koc, Bekir Celik “The impact of Number of Students per Teacher on Student Achievement”. Global Conference on Contemporary Issues in Education, 2014, Las Vegas, USA